


Энэхүү дасгал, даалгаврыг гүйцэтгэхдээ сурах бичгийн агуулгыг унших, теле хичээлээ давтан үзэх, судалж буй агуулгад холбогдох нэмэлт мэдээлэл, эх сурвалж судлах зэргээр мэдлэг, ойлголтоо бататгаарай.

Судлах бүлэг, дэд агуулга



- Дээрх 2 бүлэг сэдэв, 5 дэд агуулгын хүрээнд тулгуур ойлголт тайлбарлах, тохиолдол, эх сурвалж, мэдээлэлтэй ажиллах, жишээгээр тайлбарлах, дүн шинжилгээ хийх, үндэслэл, нотолгоо гаргах, шүүн тунгаах зэргээр мэдлэг, ойлголтоо бататган чадвар, хандлагаа хөгжүүлэх болно.
- Сурагч та илүү хариуцлагатай, цагийг зөв ашиглан ангийн найз нөхөд, багштайгаа хамтран ажиллах зэргээр бие даан бүтээлчээр суралцаарай.

	I	II	III
Түвшин	Блумын таксономийн танин мэдэхүйн үйл		
I	Сэргээн санах, ойлгох		
II	Хэрэглэх, задлан шинжлэх		
III	Үнэлэх, бүтээх		



Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хийгээрэй.

I II III

Бүлэг сэдэв/ Анги	10	Д.д	11	Д.д
Нийгэм, нийгмийн харилцаа	10-1-1а.	1, 1.1-1,3, 2, 3, 4 а,б	11-1-1а	1-1,1-2,1-3,
	10-1-1б.	1, 1.1-1,3	11-1-1б	1-1,1-2,1-3,
	10-1-1в.	1, 1.1-1,3		
	10-1-1г.	1,2,3,4 а,б		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				
Соёл	10-2-1а.	1,2, 2.1-2.4	11-2-1а	1-1,1-2,1-3
	10-2-1б.	1,2, 2.1-2.2	11-2-1б	1-1,1-2,1-3, 2-7
	10-2-1в.	1, 2, 3		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				

II

Бүлэг сэдэв/ Анги	10	Д.д	11	Д.д
Нийгэм, нийгмийн харилцаа	10-1-1а.	1, 1.1-1,2, 2, 3, 3.1-3.2	11-1-1а	2-4,4-5,4-6, 2-7
	10-1-1б.	1, 2	11-1-1б	2-4,2-5,2-6,2-7, 2-8,2-9
	10-1-1в.	1, 2,3,4.1-4.3		
	10-1-1г.	1,1.1,1.2		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				
Соёл	10-2-1а.	1, 2	11-2-1а	2-4,2-5,2-6,
	10-2-1б.	1,2, 3	11-2-1б	2-4,
	10-2-1в.	1, 1.1, 1.2	11-2-1в	2-5, 2-6, 2-7
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				

Бүлэг сэдэв/ Анги	10	Д.д	11	Д.д
Нийгэм, нийгмийн харилцаа	10-1-1а.	1.1-1.3	11-1-1а	3-8, 3-9, 3-10
	10-1-1б.	1.1-1.2	11-1-1б	3-10, 3-11, 3-10
	10-1-1в.	1,1.1-1.3		
	10-1-1г.	1,2,3		
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				
Соёл	10-2-1а.	1	11-2-1а	3-7
	10-2-1б.	1,1.1,1.2,2		
	10-2-1в.	1,2	11-2-1в	3-8, 3-9, 3-10
Эхэлсэн хугацаа				
Дууссан хугацаа				
Өөрийн үнэлгээ				
Багшийн үнэлгээ				

Суралцахуйн зураглалтай ажиллах заавар:

I алхам:	Багшийн зөвлөсөн дасгал, даалгавруудаас эхлэн ажиллаарай.
II алхам:	Өөрийн хийж чаддаг болсон дасгал, даалгавруудыг тохирох түвшний өнгөөр будаарай.
III алхам:	Тухайн бүлгийн дасгал, даалагаврыг гүйцэтгэж эхэлсэн болон дуусгасан хугацааг заавал тэмдэглээрэй.
IV алхам:	Дасгал, даалгаврыг гүйцэтгэсний дараа өөрийгөө үнэлээрэй.
V алхам:	Багшаараа үнэлүүлж, өгсөн зөвлөмжийн дагуу сайжруулаарай.

1. БҮЛЭГ - НИЙГЭМ, НИЙГМИЙН ХАРИЛЦАА

Сэдэв: 11-1-1а Нийгмийн давхраажилт

Бие даан суралцах үйлийн агуулга, төлөвлөлт

Хөтөч асуултууд:

1. Хүмүүс хоорондын ялгаа юунаас улбаатай вэ ?
2. Нийгэмд давхраажилт тогтох учир шалтгаан юу вэ?
3. Давхраажилтын ямар хэв маягууд байдаг вэ?
4. Түүхэн үеүдэд монголын нийгмийн давхраажилт ямар байсан бэ ?
5. Нийгмийн давхраажилт, байр суурь хэрхэн өөрчлөгддөг вэ?

Тулгуур ойлголтууд:

1. Хүмүүсийн хоорондын ялгаа
2. Тэгш бус байдал
3. Нийгмийн давхраажилт
4. Нийгмийн нийтлэг
5. Байр суурийн шилжилт

Agenda:

1. Сурах бичгээсээ уншиж, тэмдэглэл хөтлөх
2. Теле хичээл үзэх
3. Түүхийн хичээлтэй холбох
4. Цахим эх сурвалжаас найдвартай, албан ёсны сурвалж ашиглах
5. Дасгал даалгавраа хийж гүйцэтгэх
 - Мэдлэг ойлголтын даалгавар
 - Чадвар хэрэглээний даалгавар
 - Хандлага, төлөвшлийн даалгавар
6. Өөрийн үнэлгээний хуудсаа тэмдэглэх
- 7 Хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулах
- 8, Дэмжигч багшаас зөвлөгөө авах
9. Хичээл заадаг багшаас тусламж авах
- 10 Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хөтлөх

Даалгаврыг гүйцэтгэх зөвлөмж:

- Энэхүү ажлын хуудас нь сурагч таны өөрийн суралцахуйн хөтөч, ажлын дэвтэр тул эхлээд даалгаврын удирдамжийг анхааралтай бүрэн гүйцэд уншаарай
- Зөвлөмжийн дагуу гүйцэтгэх алхамуудыг сайтар баримтлан ажиллаарай.
- Тэмдэглэл бичих хэсэгт өөрийн санаа бодол, эргэцүүлэл, дүгнэлтээ бичихдээ аль болох үндэслэл, нотолгоотой бичээрэй.
- Тухайн даалгаврын хариултыг бичихдээ өгөгдсөн зайг баримтална гэдгийг анхаарна уу
- Сурах бичгийн дурьдсан хуудсыг заавал сайн уншиж, сонирхолтой олон янзын аргаар бүтээлч тэмдэглэл хөтөлж яваарай . Амжилт хүсье

Даалгавар 1 Тулгуур ойлголтуудын мөн чанарыг тайлбарлах
/ Сурах бичгийн 8-р талыг анхааралтай уншиж, даалгавраа хийгээрэй /
<https://econtent.edu.mn/book/11rangi>

А. Доорхи тулгуур ойлголтуудыг тохирох тодорхойлолттой нь зөв холбож бичээрэй.


- | | |
|---------------------|-------------------------|
| 1. Тэгш бус байдал | 3. Нийгмийн давхраажилт |
| 2. Нийгмийн ялгарал | 4. Нийгмийн давхраа |

..... А.БВГ
Тодорхой хэв шинжит харилцаа бүхий <u>тэгш бус</u> байдлын тогтолцоо.	Эдийн засгийн баялаг, нэр хүнд, эрх мэдэлд хүрэх <u>адил бус боломж</u> бүхий байдлыг хэлнэ.	Нийгмийн гишүүд хувийн болон нийгмийн шинжээрээ <u>зааглагдан хуваагдахыг</u> хэлнэ.	Баялаг, нэр хүнд, эрх мэдлийн хувьд ялгаатай, тодорхой <u>хэв шинжит</u> харилцаа бүхий нийгмийн нийтлэг



Б. Дээрх тулгуур ойлголтуудаас 2-ыг сонгон жишээгээр тайлбарлаарай.

1..... 2.....

В. Дээрхи тулгуур ойлголтуудын хоорондын хамаарлыг харуулсан бүдүүвчийг гүйцээнэ үү



Г. Хүмүүс хоорондын ялгаа юунаас үүдэлтэй вэ? Хувь хүний байр суурь яагаад ялгаатай байдаг тухай судлаачид янз бүрээр тайлбарладаг. Сурах бичгийн 7 талд байгаа 1,2 зургийг ажиглаад энэ талаар өөрийн санаагаа бичиж, тайлбарлаарай




Нийгэм өөрчлөгдөхтэй зэрэгцээд нийгмийн давхраажилт өөрчлөгддөг.эдгээр нь тодорхой үндэстний онцлогоос хамааран бүрэлддэг



Дээрх QR кодоор нэвтэрч сурах бичгийн 12-13 талыг уншиж дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

Даалгавар 2: Дараах зураг нийгмийн давхраажилтын ямар хэв маягыг илэрхийлж байна вэ? А ба Б баганаас тохирох хариултыг сонгоорой.



А багана

- A. Боолчлол
- B. Язгуур
- C. Каст
- D. Анги

Б багана

- A. Хаалттай давхраажилтын хэв маяг
- B. Иргэний эрхтэй эсэхээрээ ялгагддаг.
- C. Шашны номлол дахь хөдөлмөрийн хуваарь тогтоосны дагуух, хувийн байр суурийг өөрчлөх боломжгүй хаалттай давхраажилтын хэв маяг.
- D. Нээлттэй давхраажилтын хэв маяг.

Даалгавар 3: Судлаач Х.Гүндсамбуу, О.Мөнхбат, Ц.Уртнасан нарын судалгаа, ҮСХ-ны өрхийн нийгэм-эдийн засгийн байдлын судалгааны үр дүнд тулгуурлан өнөөгийн Монголын нийгмийн ангийн бүтцийг хэрхэн тодорхойлсныг 3 сонголт хийн ажиллаарай. Сурах бичиг 17

Онцлог шинж	Ангийн бүтцийн нэршил	Хэн хамаарах
1.Тэд нийт хүн амын гурав орчим хувийг эзэлдэг. 2. Бага боловсролтой, эсвэл боловсролгүй, хөдөлмөр эрхлэх чадвар муутай, тогтмол орлогогүй 3. Нийт хүн амын дийлэнхийг эзэлнэ. 4. Амьдрах арга нь гуйлга гуйх, хог түүх, тэнүүлчилдэг. 5. Нийт хүн амын 30-35 хувийг эзэлдэг хүмүүсийн тоонд манай гэр бүл багтана. 6.Нийт хүн амын гурван хүн тутмын нэг нь энэ ангид хамаарна.	A. Дээд анги B. Дунд анги C. Доод анги D. Доодын дээд E. Доодын дунд F.Ёроол хэсэг	а)Төрин дунд албан тушаалтан, хэрэгжүүлэгч агентлагийн удирдлагууд, банк санхүүгийнхэн б)Улс төрийн олигархиуд, төрийн өндөр албан тушаалтнууд с)Тогтмол ажилтай ч орлого багатай хүмүүс. д)Орон гэргүй, тэнүүлчид, буруу зуршилтан е)Тусламж, дэмжлэгээс хамааралтай амьдардаг хүмүүс. ф) Ядуу ажилчдын анги гэж нэрлэнэ.


Даалгавар 4. Нийгмийн давхраажилтын шалтгаан юу вэ? Социологийн онолууд ямар санаа дэвшүүлсэн бэ?
A. Асуултын тэмдгийн оронд дутууг нөхөн гүйцээж бичнэ / Сурах бичиг 9-11 тал /

Сонгодог сэтгэгчид		Орчин үеийн онолууд		
Төлөөлөгч	Гол санаа	Онолын хандлага	Төлөөлөгч	Гол санаа
?	Үйлдвэрлэлийн хэрэгслийг өмчлөх нь тэгш бус байдлыг үүсгэдэг	Функционал зөрчилдөөний онол	?	зохион байгуулагдсан эрх мэдэл
M.Вебер	Өмчөөс гадна орлого эрхэлж буй ажил мэргэжил гэсэн эдийн засгийн үзүүлэлт чухал	?	O.Райт	хянах эрх мэдэл Хянах эрх мэдэлгүй анги
Э.Дюркгейм	?	Бүтэц чиг үүргийн онол	?	байр суурийн нэр хүндээс хамаарсан шатлал
			Дэвис, Мур	?
			?	Хүмүүсийн зүгээс үнэлэх нэр хүнд
			Дункан	Нийгэм эдийн засгийн индекс

- Б. Хэрэв чи оршин суугаа баг, хорооны нийгмийн давхраажилтыг судлахын тулд хэний онолын хандлага, аргачлалыг үндэслэл болгон сонгох вэ?
- В. Социологийн сонгодог үеийн төлөөлөгчөөс нэгийг сонгож түүний үзэл баримтлалыг жишээгээр тайлбарлан бичээрэй
- Г. Социологийн орчин үеийн онол, түүний төлөөгчөөс нэгийг сонгож, сонгосон үндэслэл тайлбарыг бичээрэй

Даалгавар 5

A. Дараах бүдүүвчид нийгмийн давхраажилтын дутуу хэмжигдхүүнийг нөхөж бичээрэй.



- Б. Эдийн засгийн баялагт хувьцаа, хадгаламж
г.м....орно
- В. Эрх мэдэл тодорхой субъектэд хууль ёсоор олгосон эрх хэмжээгээр тодорхойлогдоно. Жишээ нь
 / сурах бичиг 14 тал/
- Г. Хувь хүний нийгэм, эдийн засгийн байр суурийг ямар үзүүлэлтээр хэмжих хэрхэн вэ? Хүмүүсээс авах судалгааны асуулга бэлтгээрэй
- Заавар: 1. Сурах бичиг 15-16 талыг уншиж энэ даалгаврыг хийж, тэмдэглэл хөтлөөрэй
 2. объектив, субъектив хэмжүүрийн ялгааг гаргаж, асуулгаа бэлтгээрэй
-

Даалгавар 6. Дараах мэдээлллийг зэрэгцүүлэн судалж, түүхэн үеүдийн Монгол улсын нийгмийн давхраажилтыг онцлог ялгааг харьцуулан тайлбарлаарай

Мэдээлэл:1 Судлаач Х.Гүндсамбуу социализмын үеийн давхраажилтыг малчдын, ажилчдын, сэхээтний, номенклатураар /Дээрээс томилогддог албан тушаалын нэрсийн жагсаалтын шатлалаар тодорхойлогдсон удирдагчдын буюу дарга нарын давхраа/ гэсэн 4 давхраажилтаар тодорхойлсон байдаг.Манай оронд бүр 1920-иад оны сүүлчээс феадлын хөрөнгийг хурааж,ядуучуудад хуваарилах замаар нийгмийн тэгш биш байдлыг устгахыг зорьдог коммунист тэгшитгэх ёсыг хэрэгжүүлж эхэлжээ.Дараагийн үе шат нь малчдын хувийн өмч болсон малыг нийгэмчлэх явдал байв.Өөрөөр хэлбэл хүн амын олонхи болсон малчдыг нэгдлийн гишүүнээр элсүүлж,мал сүргийг нь нэгдлийн буюу хоршооллын өмч болгох зорилт байсан бөгөөд үүнийг нэгдэлжих хөдөлгөөн гэдэг.

Мэдээлэл:2 1990 оны нийгмийн тогтолцооны өөрчлөлт нь социализмын үеийн давхраажилтын бүтцийг орвонгоор өөрчилсөн юм.Үүнд нэг нам ноёрхсон улс төрийн системийн задрал,зах зээлийн эдийн засгийн харилцаа,өмч хувьчлал,нээлттэй,чөлөөтэй худалдааны тэсрэлт зэрэг нь ихээхэн нөлөөсөн юм. судлаач О.Мөнхбат эд баялаг,орлого, эрх мэдэл, мэргэжил боловсрол,албан тушаал гэсэн үзүүлэлтүүдийг гол шалгуур болгон судалсны үндсэн дээр өнөөгийн нийгмийн давхраажилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:1. Дээд давхраа. 2. Дундаас дээгүүр давхраа. 3. Дунд давхраа. 4. Дундаас доогуур давхраа. 5.Доод давхраа гэж үзсэн

А. Судлаачдын үзэж байгаа давхраажилтын ангилалд тухайн үеийн монголын нийгмийн ямар онцлог ялгаа байгааг олж тайлбарлан бичээрэй ?

Б. Нийгмийн өөрчлөгдөх нь хувь хүний амьдралд ямар нөлөөлөл үзүүлдэг болохыг жишээгээр тайлбарлана уу ?

В. Нийгэмд шинэ төрлийн хэрэгцээ бий болж, түүнийг хангахаар шинэ байр суурь, шинэ дүр үүрэг үүсдэг гэж Т. Парсонс үздэг. 1990 оны өмнөх үеэс хойших үед өнөөг хүртэлх хугацаанд монголын нийгэм ямар ,ямар шинэ хэрэгцээ, байр суурь, үүрэг шинээр бий болж байна вэ ?

Дасгал 7. Байр суурийн шилжих хөдөлгөөний тодорхой жишээн дээр ажиллах

Товч агуулга: Байр суурийн шилжих хөдөлгөөн нь эцэг эхээс заяагдмал төрөлхийн байр сууриа өөрчилсөн эсэхээс хамааран А. үе хоорондын ба Б. үе дотоодын шилжих хөдөлгөөн хэмээн ялгагддаг. Эцэг эх, гэр бүлээс залгамжилсан төрөлхийн байр суурьтай нь тодорхой хувь хүний олдмол байр суурийг харьцуулахад өөрчлөгдсөн бол үе хоорондын байр суурийн шилжих хөдөлгөөн гэнэ.

- А. Үе хоорондын шилжих хөдөлгөөнд тохирох жишээг олж тэмдэглээрэй
- Б. Яагаад тохирох жишээ гэж үзсэнээ товч тайлбарлаарай
- В. Яагаад тохирох жишээ биш гэж үлдэсэнээ товч тайлбарлаарай

.....АБ
Тоосгоны үйлдвэрээс ажлын гараагаа эхэлсэн залуу дээд сургууль төгсч, барилгын инженер болжээ.Цаашдаа цехийн дарга үйлдвэрийн ерөнхий инженер,үйлдвэрийн дарга болсон байна.	Харц ард цагаан дээлт Дамдины хүү Сүхбаатар ардын хувьсгалыг өрнүүлэхэд манлайлан оролцож,цэргийн их жанжин болох жишээтэй.	Нэгэн цагт баян чинээлэг,өндөр албан тушаал хашиж байгаад архинд орж,зугаа цэнгэл хөөцөлдөн аль эсвэл эрхэлж байсан ажил төрөл нь дампуурсан

Даалгавар 8. Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж , асуудлыг судлаарай**Ядуурлын түвшин, 2010-2018**

	Ядуурлын хамралтын хүрээ, хувиар				
	2010	2012	2014	2016	2018
Улсын дундаж	38.8	27.4	21.6	29.6	28.4
Хот	33.2	23.3	18.8	27.1	27.2
Хөдөө	49.0	35.4	26.4	34.9	30.8

Хөдөө орон нутагт ядуурлын түвшин өндөр хэвээр байгаа боловч Монгол Улсын нийт хүн амын гуравны хоёр нь хот суурин газарт амьдарч байгаагаас ядуурал хот суурин газарт нэмэгдэж байна. Хот суурин газарт амьдарч буй ядуусын эзлэх хувь 2016 онд 62.1 байсан бол 2018 онд 63.5 болсон бөгөөд Улаанбаатар хотод 2018 оны байдлаар нийт ядуусын 41.8 хувь нь амьдарч байна.

Эх сурвалж: <https://www.worldbank.org/mn>

А. Судалгааны мэдээлэлд нийгмийн ямар асуудлыг хөндсөн байна вэ ?

Б. Асуудлын гол шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйл, түүний үр дагаврын талаар жишээ гарган тайлбарлаарай ?

В. Хөндөгдсөн асуудлыг шийдэх хамгийн боломжит арга зам, шийдлийн хувилбар дэвшүүлээрэй ?

Г. Дэвшүүлсэн хувилбараас хамгийн чухал гарц шийдлийнг сонгож, давуу ба сул талыг үнэлээрэй

Д. Дэвшүүлж буй хувилбараа хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан тайлбарлаарай

Даалгавар 9. А баганын нэр томъёо бүрт Б баганын тодорхойлолтыг тохируулаарай**Б. багана****А багана**

- 1. А. Анги
- 2. Б. Боолчлол
- 3. В. Шашин
- 4. Г. Энэтхэг
- 5. Д. Язгуур
- 6. Е. Эдийн засаг

а. Иргэний эрхтэй эсэхээрээ ялгаатай, нэг нь нөгөөгийнхөө өмч нь болж байдаг давхраажилтын хэв маяг.

б) Кастын тогтолцоо нь (...) давхраажилтын уламжлалт тогтолцоо.

в) Энэ нь (...) номлолд нь батжсан байх хувийн байр суурь өөрчлөгдөх ямар ч боломжгүй хаалттай давхраажилт.

г) Улс төрийн үйл ажиллагаанд оролцох эрхээрээ ялгаатай, эрх зүйн хувьд баталгаажсан, угсаа залгамжлах замаар олгогддог, хаалттай давхраажилтын систем

д) Аж үйлдвэржилтийн харилцааны үр дүнд тогтсон, (...) ялгаанаас үүдэлтэй, харьцангуй нээлттэй буюу хувийн байр сууриа өөрчлөх боломжтой давхраажилтын хэв маяг бол (...).

Нас жендер, үндэс, угсаа арьс өнгөний байр суурь нь хүнд заяагдмал шинжтэй. Гэхдээ нийгэмд эзэлж буй байр суурийн ялгаа нь тэдний төрөлх шинжтэй бус, харин ялгаатай боломжийг олгож буй нийгмийн бүтэц, соёлоос хамаарна




<https://econtent.edu.mn/book/11rang>

Дээрх QR кодоор нэвтэрч сурах бичгийн 23-25 талыг уншиж судлаарай.

Даалгавар 10. Мэдээллийг уншаад асуултанд хариулж, хамаарагдах ойлголтуудыг сурах бичгийн 23-25 талыг уншиж, тэмдэглэл хөтлөөрэй

1. МОНГОЛ УЛС ЖЕНДЭРИЙН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ОЛОН УЛСАД:



НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс нөхөн үржихүйн эрүүл мэнд, улс төрийн төлөөлөл, ажиллах хүчний оролцооны үзүүлэлтэд суурилан гаргадаг Жендэрийн тэгш бус байдлын үзүүлэлтээр 2018 оны байдлаар Монгол Улс 189 орноос 71-р байранд, Хүний хөгжлийн үзүүлэлтэд суурилан гаргадаг Жендэрийн Хөгжлийн Индексээр 92-р байранд орсон байна.

2020 оны байдлаар Дэлхийн Эдийн Засгийн Форумаас гаргадаг жендэрийн зөрүүтэй байдлын үзүүлэлтээр (Global Gender Gap Index Report) дэлхийн улс орнууд жендэрийн тэгш байдлыг хангахад дунджаар 68.6%-тай байна. Монгол Улс нь 70,6% үзүүлэлтээрээ нийт 153 орны дунд 79-р байранд орж байна. Монгол Улсад жендэрийн тэгш байдлыг хангаж, Тогтвортой хөгжлийн зорилт 2030 -ын хүрээнд тавьсан зорилгоо биелүүлэхэд эмэгтэйчүүдийн улс төр дэх төлөөлөл болон ажиллах хүчний оролцооны түвшин хангалтгүй байгаа нь гол саад болж байгааг дээрх үзүүлэлтүүд харуулж байна. Мөн эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдийнхээс 9,7 жилээр богино

Эх сурвалж: <https://www.gender.gov.mn/publications>

А. Мэдээлэлд ямар асуудлыг хөндсөн байна вэ ?

Б. Манай улсад жендэрийн тэгш бус байдалд ямар хүчин зүйл хамгийн их нөлөөлж байна вэ?

В. Дараах тулгуур ойлголт бүрийн тайлбар, тодорхойлолтыг нөхөж бичээрэй.
/ сурах бичгээс 24-25 тал сайн уншиж судлаарай /

Тулгуур ойлголт	Тайлбар, тодорхойлолт
Хүйс	
Жендер	
Угсаатны нийтлэг	
Насны нийтлэг	
Шашны нийтлэг	

Бататгах асуулт:

1. Хүмүүс хоорондын ялгаа юунаас улбаатай вэ ?
2. Нийгэмд давхраажилт тогтох учир шалтгаан юу вэ?
3. Давхраажилтын ямар хэв маягууд байдаг вэ?
4. Түүхэн үеүдэд монголын нийгмийн давхраажилт ямар байсан бэ ?
5. Нийгмийн давхраажилт, байр суурь хэрхэн өөрчлөгддөг вэ?



ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Дэд сэдэв	Дасгал даалгаврыг гүйцэтгэсэн чадвар	R	A	G	Comments
Нийгмийн давхраажилт	<ul style="list-style-type: none">• Нийгмийн давхраажилтын онол, хэмжигдэхүүн, хэв маяг, шилжих хөдөлгөөнийг нэрлэж, тайлбарлаж чадсан• Боолчлол, каст, язгуур, анги бол давхраажилтын дөрвөн хэв маяг болдог тухай мэддэг• Нийгмийн давхраажилтын онолын төлөөлөгчдийн үзлийн ялгааг харьцуулах• Түүхэн үеүдийн Монгол улсын нийгмийн давхраажилтыг баримт, эх сурвалжийг тайлбарлах• Нийгмийн байр суурийн шилжих хөдөлгөөний хэлбэрийг жишээн дээр ялгаж чаддаг• Хэд хэдэн эхийг харьцуулан асуудлыг дагуу шинжлэн дүгнэж чаддаг	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

R- багшийн тусламж авна

A- дахин давтаж нэмэлт дасгал ажиллана.

G- өөрөө сайн хийж чаддаг болсон

Сэдэв:11-1-16 Нийгмийн өөрчлөлт

Бие даан суралцах үйлийн агуулга төлөвлөлт:

Хөтөч асуултууд

1. Нийгмийн өөрчлөлт гэж юу вэ
2. Нийгмийн өөрчлөлтийн шалтгаан, түүнд нөлөөлж байгаа хүчин зүйлыг онолууд хэрхэн тайлбарладаг вэ
3. Нийгмийн өөрчлөлт хувь хүний амьдрал, үйлдэлд хэрхэн нөлөөлдөг вэ
4. Хүн амын өсөлт, Соёл технологи, хүрээлэн буй орчин, дайн улс төрийн мөргөлдөөн, даяаршил нийгмийн өөрчлөлтөд хэрхэн нөлөөлж байна вэ?
5. Нийгмийн шинэчлэлтийн давуу болон сөрөг талыг ялгаж, өөрийн дүгнэлтийг илэрхийлнэ үү
6. Даяаршлын нөлөөгөөр цахим орчинд ямар өөрчлөлт гарч байна вэ?

Тулгуур ойлголтууд:

1. Нийгмийн өөрчлөлт
2. Нийгмийн өөрчлөлтийн хэв маяг
3. Нийгмийн өөрчлөлтийг тайлбарладаг онолууд
4. Шинэчлэл
5. Нийгмийн хөдөлгөөн
6. Хувьсал
7. хувьсгал

Agenda:

1. Сурах бичгээсээ унших
2. Теле хичээл үзэх
3. Түүхийн хичээлтэй холбох
4. Цахим эх сурвалжаас найдвартай, албан ёсны сурвалж ашиглах
5. Дасгал даалгавраа хийж гүйцэтгэх
 - Мэдлэг ойлголтын даалгавар
 - Чадвар хэрэглээний даалгавар
 - Хандлага, төлөвшлийн даалгавар
6. Өөрийн үнэлгээний хуудсаа тэмдэглэх
7. Хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулах
8. Дэмжигч багшаас зөвлөгөө авах
- 9 хичээл заадаг багшаас тусламж авах
10. Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хөтлөөрэй

11-1-1.6 Нийгмийн өөрчлөлт

Даалгавар 1. Нийгмийн өөрчлөлт гэж юу вэ



Даалгавар 2 Нийгмийн ямар хэв маягуудыг хэрхэн тодорхойлсон бэ

Заавар: Дээрх QR кодоор нэвтэрч сурах бичгийн 29-32 талыг уншиж, доорхи нүдэнд тэмдэглэж бичээрэй.

К.Маркс

Шалгуур:-----

1. -----
2. -----
3. -----
4. -----
5. -----

Г.Ленский,Ж Ленский

Шалгуур:-----

1. -----
2. -----
3. -----
4. -----

Тённис

Шалгуур: -----

Т.Билтон

Шалгуур: -----

1. -----
2. -----
3. -----


Даалгавар 3. Нэгтгэн
дүгнэх

Дээрхи сэтгэгчид нийгмийн хэв маягийг
ангилахдаа ямар шалгуурыг авч үзсэн бэ

Хэв маягийн шалгуур

1	К Маркс
2	Г.Ленский
3	Ф.Тённис
4	Т. Билтон

Дасгал 4. Нийгмийн өөрчлөлтийг тайлбарласан дараах онолуудыг үзэл санааг сурах бичгийн 33-34 талаас уншиж, гүйцээн тэмдэглээрэй



Карл Маркс

Нийгэм өөрчлөгдөх шалтгаан юу вэ?

.... бол нийгмийн өөрчлөлтийн

Нийгэм хэрхэн өөрчлөгддөг вэ?


Нэг үйлдвэрийн хэрэгслийг нөгөөх нь солих замаар нийгэм өөрчлөгддөг.



Т.Парсонс



М.Вебер



Г. Ленский

Даалгавар 5 Нэгтгэн дүгнэх

Нийгмийн өөрчлөлтийг тайлбарлах онолуудын нийтлэг ба ялгаатай талуудыг өөрийн ойлголтоор дүгнэн бичээрэй



Даалгавар 6.

А. Дараах хэв маягийг тохирох шинжээр нь хүснэгтэд зөв нөхөж байрлуулаарай
 Ан агнуурын нийгэм, Цэцэрлэг аж ахуйн нийгэм Газар тариалангийн нийгэм Аж
 үйлдвэржсэн нийгэм

A		1	Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх болсноор хот үүссэн. Ураг төрлийн холбоонд суурилагаа больсон. Хамгийн өргөн тархсан нийгэм
B		2	Ураг төрлийн холбоонд суурилсан, олон төрлийн овгуудаас тогтох ба нэмүү өртөг бүтээх түвшинд хүрээгүй,
C		3	Гэр бүл, институтын нөлөө багассан, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн асар их үйлдвэрлэдэг.
D		4	Улс төрийн бүтэц үгүй, энгийн зэвсэг ашигладаг, овгийн байгуулал бүхий нийгэм

Б. Нийгмийн өөрчлөлтийн хэв маягийн шинэчлэлд ямар хүчин зүйл илүү нөлөөлж байна вэ?

.....

В. Нийгэмд шинэ төрлийн хэрэгцээ бий болж, түүнийг хангахаар шинэ байр суурь, шинэ дүр үүрэг үүсдэг гэж Т. Парсонс үздэг. 1990 оны өмнөх үеэс хойших үед өнөөг хүртэлх хугацаанд монголын нийгэм ямар ,ямар шинэ хэрэгцээ, байр суурь, үүрэг шинээр бий болж байна вэ ?

.....

Даалгавар 7. Сурах бичгийн 34-35 талыг анхааралтай уншиж дараах хүчин зүйлүүд нийгмийн өөрчлөлтөд нөлөөлдөг болохыг нотолсон жишээг олж хүснэгтэд тэмдэглээрэй

№	Нөлөөлөх хүчин зүйл	Жишээ
1	Хүн амын өсөлт	
2.	Соёл,технологи	
3	Хүрээлэн буй орчин	
4	Дайн, улс төрийн мөргөлдөөн	

Б. Сурах бичгийн 36-р талд байгаа Үйл ажиллагаа 1,12 Аль нь хувьсгалын жишээ болох вэ? даалгаврын 2 асуултанд хариулаарай

1.

2.



Дасгал 8. Дараах эхийг харьцуулан уншиж, асуултанд хариулаарай

Д нь 1915 онд төрсөн бөгөөд 16 насандаа нөхөрт гарсан. Түүний эцэг эх нь нөхрийн талаас бэр гуйсныг зөвшөөрсөн тул анх удаа харсан нөхөртэйгээ гэрлэсэн байна. Таван хүүхэд төрүүлсэн ч 3 нь эндсэн бөгөөд настай эмэгтэйн тусламжтайгаар гэртээ амаржсан ажээ.

А нь 1937 онд төрсөн бөгөөд бага сургуулиа төгсөөд, үргэлжлүүлэн сурахыг хүссэн ч эцэг эх нь зөвшөөрөөгүй байна. 17 насандаа хайр сэтгэлтэй хүнтэйгээ учирч гэрлэсэн байна. Тэрээр нийт 9 хүүхэд төрүүлсэн бөгөөд ууган хүүхдээ гэртээ, бусдыг нь эмнэлэгт төрүүлсэн байна.

Ц нь 1970 онд төрсөн бөгөөд цэцэрлэг, сургууль дамжсаар 1993 онд их сургуулиа дүүргэсэн байна. Ажил хөдөлмөр эрхэлсээр 30 орчим насандаа хайр сэтгэлтэй хүнтэйгээ гэрлэж, 2 хүүхэд төрүүлжээ. Бага хүүхдээ төрүүлсний дараагаар жирэмсэлтээс сэргийлэх арга хэрэглэх болсон байна.


1. Эхүүд дэх нийтлэг болон ялгаатай талуудыг тодорхойлно уу?
2. Түүхэн үеүдэд эмэгтэйчүүдийн гэрлэлтэд ямар өөрчлөлт гарсан байна вэ?
3. Түүхэн үеүдэд төрөлттэй холбоотой ямар өөрчлөлт гарсан байна вэ?
4. Гэр бүл, эрүүл мэндийн институтэд гарсан өөрчлөлтийн талаар дүгнэнэ үү?



Даалгавар 9. Дасгал 5 ын гүйцэтгэлд тулгуурлаж, дараах нотолгоог баталсан жишээ кейс бичнэ үү


Нийгмийн өөрчлөлт нь хувь хүний амьдрал, үйлдэлд нөлөөлж байна. жишээ гарган дүгнэж бичээрэй

Дасгал 10 . Шинэчлэлийн үр нөлөө түүний давуу сул талыг харуулсан оюуны зураглалыг гүйцээж бүтээгээрэй Сурах бичгийн 31 талыг сайн уншиж судлаарай



- Б.. Оюуны зураглалаа тайлбарлаж бичээрэй
- В. Нийгмийн хөгжилд иргэн хүн хувь нэмрээ оруулах арга замуудыг жагсаан нэрлээрэй

Даалгавар 11 Дэлхийг хамарсан алсын харилцаа холбооны арга, хэрэгслүүд бидний бодол санаа, хийх юмсыг өөрчилсөөр байна. Сошиал нийгэм дэх дараах сүлжээний харилцан хамаарлыг анхааралтай ажиглан , асуултанд хариулж бичээрэй



- А. Сошиал сүлжээ та нарын амьдрал, үйлдэлд ямар сайн үр нөлөө үзүүлж байна вэ ?
- Б. Сошиал нийгэм та нарын амьдралд ямар сөрөг нөлөө үзүүлж байна вэ вэ?
- В. “Сошиал орчныг хөтлөх үү, хөтлөгдөх үү “сэдвээр асуудал дэвшүүлсэн эссе бичээрэй

Бататгах асуулт:

1. **Нийгмийн өөрчлөлт гэж юу вэ?**
2. Нийгмийн өөрчлөлтийн шалтгаан юу вэ ?
3. Нийгмийн өөрчлөлтийн ямар хэв маягууд байдаг вэ
4. Нийгмийн өөрчлөлтийн онолуудын ялгааг тайлбарлана уу



ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Дэд сэдэв	Дасгал даалгаврыг гүйцэтгэсэн чадвар	R	A	G	Comments
Нийгмийн давхраажилт	<ul style="list-style-type: none">• Нийгмийн өөрчлөлтийн хэв маягийн ангилал, онолын үзэл баримтлалын ялгааг тайлбарлаж чаддаг• Нийгмийн өөрчлөлтийн шалтгаан, түүнд юу нөлөөлдөг болохыг тайлбарласан онолын төлөөлөгчдын үзэл санааг мэддэг• Нийгмийн өөрчлөлт хувь хүний амьдрал, үйлдэлд хэрхэн нөлөөлдөг болохыг жишээгээр илэрхийлж, дүгнэж чадна• Хүн амын өсөлт, Соёл технологи, хүрээлэн буй орчин, дайн улс төрийн мөргөлдөөн, даяаршил нийгмийн өөрчлөлтөнд хэрхэн нөлөөлж байна вэ?• Нийгмийн шинэчлэлтийн давуу болон сөрөг талыг ялгаж, өөрийн дүгнэлтийг хэлж чадна• Даяаршлын нөлөөгөөр социал орчинд зөв харьцах өөрийн соёлыг бий болгож чадна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

R- багшийн тусламж авна

A- дахин давтаж нэмэлт дасгал ажиллана.

G- өөрөө сайн хийж чаддаг болсон

11-2-2. Соёл

11-2-1a Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ

Бие даан суралцах үйлийн агуулга, төлөвлөлт

Хөтөч асуултууд:

1. Соёлын үйлдвэрлэл гэж юу вэ
2. Соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ байгууллага ямар чиг үүрэгтэй вэ?
3. Соёлын үйлдвэрлэл ямар ач холбогдолтой вэ
4. Соёлын аялал жуулчлал гэж юу вэ?
5. Соёлын аялал жуулчлалыг цаашид хэрхэн хөгжүүлэх вэ?

Тулгуур ойлголтууд:

1. Соёлын үйлдвэрлэл
2. Соёлын үйлдвэрлэлийн үндэсний хөтөлбөр
3. Соёлын үйлдвэрлэл ба ДНБ
4. Соёлын аялал жуулчлал
5. Дотоодын ба олон улсын аялал жуулчлал


Agenda:

1. Сурах бичгээсээ унших
2. Төле хичээл үзэх
3. Түүхийн хичээлтэй холбох
4. Цахим эх сурвалжаас найдвартай, албан ёсны сурвалж ашиглах
5. Дасгал даалгавраа хийж гүйцэтгэх
 - Мэдлэг ойлголтын даалгавар
 - Чадвар хэрэглээний даалгавар
 - Хандлага, төлөвшлийн даалгавар
6. Өөрийн үнэлгээний хуудсаа тэмдэглэх
7. Хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулах
8. Дэмжигч багшаас зөвлөгөө авах
9. Хичээл заадаг багшаас тусламж авах
10. Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хөтлөөрэй

Дасгал 1. Соёлын үйлдвэрлэл сэдэвт хамаарагдах ойлголтуудаас сонгож “Сум тойрог” дүрс ашиглан харилцан хамаарлыг харуулсан бүдүүвч зурж, тайлбарлах

Дасгал ажиллах заавар:

1. Өгөгдсөн ойлголтыг жагсаалтыг ажиглах
2. 3-4 гол ойлголтыг сонгох
3. Сум тойрог аргаа хэрэглэн зургаар дүрслэх
4. Хоорондын хамаарлыг жишээгээр тайлбарлах
5. Өөрийн дүгнэлтийг товч бичих




1. Сум ба тойрог

1. Тулгуур ойлголтууд.

- | | |
|---------------------|--------------------------|
| 1. Даяаршил | 4. Соёлын үйлдэрлэл |
| 2. Үндэсний өв соёл | 5. Соёлын аялал жуулчлал |
| 3. Унаган байгаль | 6. Соёлын бодлого |

3 Чиний бүтээл



4. Өөрийн зурсан бүдүүвч дэх ойлголтуудын харилцан хамаарлын амьдралын жишээ татаж тайлбарлаарай

.....

5. Дасгалыг хийж дуусад өөрийн товч дүгнэлтийг бичээрэй

.....

Өөрийн хийж гүйцэтгэсэн дасгалыг дараах үнэлгээний рубрикээр үнэлж, дахин сайжруулаарай

Шалгуур	Хангалттай сайн 3 оноо	Дундаж 2 оноо	Дэмжлэг шаардлагатай 1 оноо
Бүдүүвчийг сэтгэн зөв зураглаж буй байдал	бүрэн зурагласан	дутуу зурагласан	Цөөн тооны ойлголтыг зурагласан эсхүл огт зураглаагүй
Сонгосон ойлголтуудын холбоо хамаарлын илэрхийлсэн байдал	Уялдаа холбоог сайтар гаргасан	Уялдаа холбоог дутуу эсхүл алдаатай гаргасан	Ойлголтуудын хоорондын холбоог буруу гаргасан
Хоорондын хамаарлыг тайлбарлаж, дүгнэсэн эсэх	Бүдүүвч дэх хамаарлыг бүрэн тайлбарлаж, дүгнэсэн	Хамаарлыг дутуу тайлбарласан, дүгнэлт гүйцэт биш	Тайлбарлахдаа дутуу эсвэл алдаатай тайлбарласан дүгнэлт бичээгүй


Дасгал 2. Манай улсын 2015 онд баталсан “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг ямар хүрээнд хэрэгжүүлэхээр заасан бэ? Тэдгээрийг нэрлэж, асуултын дагуу хүснэгтийн дутууг гүйцээн бөглөнө үү? / Сурах бичиг 43 тал /

<https://www.legalinfo.mn/annex/details/7173?lawid=11783->

	Хүрээ чиглэл	Түүний ач холбогдол	Цаашид хэрхэн хөгжүүлэх чиг хандлага байна вэ ?
	Кино урлаг -Театрын урлаг (драма,мюзикл, комеди,) -Циркийн урлаг Хөгжмийн урлаг.	-Оюуны бүтээл, инноваци зохиогчийн эрхэд тулгуурлан эдийн засгийн эргэлтэд оруулах	Шударга өрсөлдөөнийг бий болгох - Үндэсний онцлогт тохирсон - Зах зээлийг тэлэх
	?	дизайн урлагийн салбар бол нийгэм соёлын онцлогийг маш тодоор илтгэж чаддаг	?
	тайзны уран бүтээл	?	?
	Соёлын аялал жуулчлал	Соёлын өв, байгаль орчны бодит нөөц болон боловсон хүчний ур чадвар шинжлэх ухаан, технологид тулгуурлан хөгждөг онцлогтой	?

Дасгал 3. 1970- аад оноос нэвтэрч эхэлсэн Соёлын аялал жуулчлал нь хоёр төрөлтэй. Хүснэгтийг нөхөж, доорхи асуултын дагуу тайлбарлаж бичнэ үү

А. Соёлын аялал, жуулчлалын төрлийг гүйцээн нөхөж бичнэ үү?



Б. Манай улсын соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нэн түрүүнд тулгамдаж байгаа ямар асуудлууд байна вэ ? Яагаад ?

.....

В. Тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ? 2-3 хувилбар дэвшүүлээрэй

.....

Даалгавар 4. Мэдээллийг харьцуулан судалж асуултын дагуу дүн шинжилгээ хийнэ үү.

1



“Марко Поло” киноны зураг авалтыг Казахстанд хийхэд нэг сарын дотор 26 сая доллар төлж байна. Хэрвээ энэ зураг авалтыг Монголд хийсэн бол манай улсын бүх продакшнууд хөл дээрээ босох байсан. Казахстан юугаар илүү байсан, тэнд кино үйлдвэр байсан

2



“Made in Mongolia” гэсэн брэнд нэр шинэ соргог, онцлог, байгалийн гаралтай, цэвэр бүтээгдэхүүн байдаг. Олон улсад экспортын татваргүй гардаг. Монголын брэндийг дэлхийн зах зээлд гаргаснаар түүхий эд материал үнэгүй шахам гадагш гарах биш, нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн болж гарах нь хаа хаанаа ашигтай, Монгол улсын эдийн засагт өндөр үр өгөөжтэй нөөц болон үлдэнэ гэж үзэж байна.

3



“Монгол үүлэн хээ дэлхийн зарим дизайнерыг урамшуулж байгаа”
Мари Катранзу тэргүүтэй алдартай дизайнерууд өнгөрсөн намар, өвлийн загварууддаа бидний нэг их тоогоогүй урлагийн элементээр онцгойрч чадсан байна. Мөн Ази-Номхон далайн бүс нутаг дахь хамгийн том контемпорари триенналд монгол зургийн дөрвөн уран бүтээлч оролцож, дэлхийн орчин үеийн урлаг одоо монгол зургийг нэлээн сонирхож байгаа гэдгийн нэг илрэл болсон.

А. Хүснэгтийн асуултын дагуу мэдээллийг цуглуулаарай

Мэдээлэл №	Ямар чухал санааг хөндөж байна	Бид юуг мэдэж, юуг хийх хэрэгтэй байна вэ
1		
2		
3		

Б.. Соёлын үйлдвэрлэл эрхэлдэг байгууллагуудыг нэрлэнэ үү? Тэдгээрийн онцлог, чиг үүргүүдээс бичнэ үү.

.....

В. Манай улсад соёлын үйлдвэрлэл хөгжүүлэхэд ямар давуу ба сул тал байна вэ?

.....

Г. Дээрхи мэдээлэлд манай улсын соёлын аялал жуулчлал хөгжүүлэхэд ямар боломж байгааг илэрхийлж байна вэ?

.....

Сурах бичгийн 42-43 талыг сайн уншиж ,дээрхи асуултанд хариулаарай

Дасгал 4. Стастикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнгээ тайлбарлаарай



<https://www.1212.mn>



<https://medium.com/>

- А. Манай орны жуулчдын тоог дэлхийн улс орнуудын жуулчдын тоотой харьцуулж, хүснэгт 1- т ангилан бүлэглээрэй
 Б. Дараа нь доорхи 3 асуултанд хариулж бичээрэй

Хүснэгт 1

он	Хөгжингүй орнууд	Хөгжиж буй орнууд	Дэлхий	Монгол
2010				
2013				
2014				

Асуулт:

1. Жуулчдын талаарх мэдээллийг ямар хэлбэрээр дүрслэн харуулсан байна вэ?
2. Монгол улсын тоог хүснэгтийн нэрэнд яагаад дундаж гэдэг үг ороогүй вэ? Учрыг нь тайлбарлана уу.
3. Жуулчдын тооны өөрчлөлтөд ямар хүчин зүйлс нөлөөлж байна вэ?

Даалгавар 5 Манай улсын соёлын аялал жуулчлалын хөгжилд ямар давуу, ба сул тал байна вэ?

А. Дараах жагсаалтыг хамгийн чухлаар нь 1-5 эрэмбэлж тоог нүдэнд тэмдэглээрэй. Хамгийн эхний нэгийг сонгож доорхи асуултанд хариулж, өөрийн бодлоор гарц шийдлийг тайлбарлаарай / сурах бичгийн 44-46 талыг сайн уншиж судлаад даалгавраа хийгээрэй/

Давуу тал	Сул тал
<input type="checkbox"/> Нүүдэлчдийн хосгүй ёс заншил, уламжлал, түүх соёлын давтагдашгүй үнэт өв, унаган төрхөө харьцангуй сайн хадгалж үлдсэн үзэсгэлэнт газар нутаг <input type="checkbox"/> Дэлхийд алдар цуугаа дүүрсгасан их эзэн Чингис хаан, түүний өв залгамжлагчдын үлдээсэн түүхийн өв; <input type="checkbox"/> Монголчуудын зочломтгой, найрсаг зан чанар. Бусад -----	<input type="checkbox"/> Дэд бүтэц муу, жуулчин тээвэрлэх, хүлээн авах хүчин чадал бага; <input type="checkbox"/> Монгол орны эрс тэс цаг уурын байдал; <input type="checkbox"/> Мэргэжлийн ажиллах хүчин дутмаг, аялал жуулчлалын салбарын сургалт, судалгааны чанар хангалтгүй; <input type="checkbox"/> Жуулчдыг татахад чиглэсэн маркетинг, гадаад сурталчилгааны ажил хангалтгүй; <input type="checkbox"/> Үйлчилгээний стандарт, аюулгүй байдал хангагдаагүй. Бусад -----

Б. Цаашид хөгжүүлэхийн тулд:

1. Давуу талаа яаж ялгарах боломж болгох вэ?

.. Монголын аялал жуулчлалын байгууллагууд бүгд адилхан үйлчилгээтэй байх биш, харин хоорондоо ялгаран хөгжиж хэрэгтэй.

.....

2. Сул талаа хэрхэн сайжруулах ?

.....

3. Орон нутгийн хөгжилд соёлын аялал жуулчлал ямар эерэг үр дүн үзүүлэх вэ?

.....

4. Манай улсын хөгжилд соёлын аялал жуулчлал ямар эерэг үр нөлөө үзүүлэх вэ?

.....

Даалгавар 6 . Сурах бичгийн 44 тал дахь Үйл ажиллагаа 2.3 ДНБ ба Аялал жуулчлалын салбарын нийт орлого статистик мэдээллийг шинжилж, дараах асуултанд хариулаарай

Асуулт:

1. Аялал жуулчлалын салбарын орлого 1%- иар өсөхөд түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээ хэдэн хувиар өсөж байна вэ?

2. Аялал жуулчлалын салбарын орлого болон түүний ДНБ-д эзлэх хувь хэмжээг графикаар илэрхийлж тэдгээрийн хоорондын хамаарлын чиглэлийг тогтооно уу

3. Графикаас ямар асуудал ажиглагдаж байна вэ?

4. Тус асуудалд хүргэсэн шалтгааны талаар юу гэж бодож байна вэ?

11-2-1a Соёлын үйлдвэрлэл, монголчуудын соёл

Даалгавар 7. Эхийг уншиж, зургийг ажиглан асуултын дагуу шинжлээрэй

Жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилго бүхий 10 дахь удаагийн Бүргэдийн баяр эхэллээ. “Бүргэдээр ан хийх уламжлал Төв Азийн нүүдэлчдийн дунд 6000 жилийн өмнө үүсэж,өдий хүртэл хадгалагдан ирсэн гэж үздэг.Уг зан үйлийг 2010 онд ЮНЕСКО-гийн Хүн төрөлхтний соёлын өвд албан ёсоор бүртгэсэн. Хүн төрөлхтний соёлын өвийг тээж яваагийн хувьд манай ард түмэн уг уламжлал, зан заншлыг сэргээж, хойч үедээ өвлүүлэх үүрэгтэй. /Өнөөдөр сонин 2018,03,05 №041/



1. Дээрхи эхэд монголчуудын ямар өвөрмөц зан үйлийг харуулсан бэ ? Түүний үндсэн шинжүүдийг нэрлэж тайлбарлаарай

.....

2. Соёлын ямар өвд хамаарах вэ


.....

3. Үндэсний уламжлалт соёл, зан заншлаа эрхэмлэн дээдэлж, хайрлан хамгаалахын ач холбогдлыг тодорхойлоорой

.....

4. Монгол үндэсний соёл, уламжлалт зан заншлаа хайрлаж хамгаалахыг бусдад уриалсан постер бүтээж, өөрийн цахим хуудсаараа дамжуулж найзууддаа илгээгээрэй

- Гар утасны ” Canva “ аппликэйшн ашиглаарай
 Дараах алхамаар гүйцэтгэнэ
- ✓ Судлах сэдвээ сонгоно.
 - ✓ Сэдвийн хүрээнд мэдээлэл цуглуулна.
 - ✓ Мэдээллээ боловсруулна.
 - ✓ Постороо бэлтгэнэ.
 - ✓ Цахим хуудсандаа байрлуулна



Бататгах сорил

1. Тухайн хүний оюуны өмчөөр хамгаалагдсан соёлын агуулга бүхий бараа бүтээгдэхүүн, түүний үйлдвэрлэл, хуваарилалт, нийлүүлэлтийн тогтолцоог.....гэнэ.
 А.Соёлын дархлаа В. Соёлын үйлдвэрлэл
 С.Соёл судлал D. Соёлын бүтээгдэхүүн E.Соёлын менежмент
2. “Соёлын үйлдвэрлэл” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд үл хамаарах салбарыг тэмдэг
 А. дизайн, дүрслэх урлаг В. мэдээллийн технологи
 С. соёлын өв D. тайзны уран бүтээл E. кино урлаг
3. Үндэсний соёлын өвөрмөц өв санг дэлхий нийтэд үзүүлэн таниулах хэрэгцээ улам нэмэгдэж байгаа өнөө үеийн соёлын солилцооны гол хөтлөх хүч нь дотоодын болон олон улсынмөн.
 А.Соёлын аялал жуулчлал В.Соёлын үйлдвэрлэл
 С. Соёлын даяаршил D Соёлын дархлаа E.Соёлын арга хэмжээ
4. Соёлын үйлдвэрлэлийг нэрлэхдээ илүүц зүйл дурдсан бол аль нь вэ?
 А.Соёлд суурилсан бүтээлч үйлдвэрлэл В.Бүтээлч, шинэ эдийн засаг
 С.Утаагүй үйлдвэрлэл D.Соёлын орон зай
 E.Чөлөөт цагт зориулсан үйлдвэрлэл \шоу бизнес\



ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Дэд сэдэв	Дасгал даалгаврыг гүйцэтгэсэн чадвар	R	A	G	Comments
Соёлын үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> Соёлын үйлдвэрлэл түүнийг бүтээхэд оролцдог хувь хүн, байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүргийг мэднэ Соёлын үйлдвэрлэлд хамаарах тоон үзүүлэлтүүдэд үндэслэж, ДНБ-д оруулах хувь нэмрийг тооцоолж чаддаг Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдлыг жишээнд тулгуурлан тодорхойлж чадна Манай оронд соёлын үйлдвэрлэл үйлчилгээнийбайгууллагыг хөгжүүлэх давуу болон сул талыг ялгаж, өөрийн дүгнэлтийг хэлж чадна Соёлын аялал жуулчлал, түүнд тавигддаг зарчмуудыг тодорхойлж мэднэ Соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх тулгамдаж буй асуудлын шалтгааныг тодорхойлж, шийдэх гарц шийдлийг дэвшүүлж чадна 				

- R**- Багшийн тусламж авна
- A**- Дахин давтаж, нэмэлт дасгал ажиллана.
- G**- Өөрөө сайн хийж чаддаг болсон

11-2-16. Соёлын өөрчлөлт

Бие даан суралцах үйлийн агуулга, төлөвлөлт

Хөтөч асуултууд:

1. Соёлын өөрчлөлт гэж юу вэ
2. Соёлын өөрчлөлт, харилцан хамааралд нөлөөлдөг хүчин зүйл юу вэ?
3. Соёлын хожимдол, түүнээс ямар үр дагаврууд урган гардаг вэ?
4. Монголчуудын уламжлалт соёл, зан заншлын өвөрмөц онцлог юу вэ? хэрхэн хайрлан хамгаалж, авч явах вэ ?
5. Соёлын даяаршил, соёлын эрх чөлөөний тухай ойлголтууд түүний үндэсний соёлд үзүүлэх нөлөөг хэрхэн тодорхойлдог вэ?

Тулгуур ойлголтууд:

1. Соёлын өөрчлөлт
2. Соёлын нээлт, бүтээл
3. Соёлын нэвчилт, харилцан хамаарал
4. Соёлын хожимдол
5. Соёлын даяаршил
6. Соёлын дархлаа
7. Соёлын эрх чөлөө
8. Соёлын орон зай

Agenda:

1. Сурах бичгээсээ унших
2. Теле хичээл үзэх
3. Түүхийн хичээлтэй холбох
4. Цахим эх сурвалжаас найдвартай, албан ёсны сурвалж ашиглах
5. Дасгал даалгавраа хийж гүйцэтгэх
 - Мэдлэг ойлголтын даалгавар
 - Чадвар хэрэглээний даалгавар
 - Хандлага, төлөвшлийн даалгавар
6. Өөрийн үнэлгээний хуудсаа тэмдэглэх
7. Хэрхэн сайжруулах төлөвлөгөө боловсруулах
8. Дэмжигч багшаас зөвлөгөө авах
9. Хичээл заадаг багшаас тусламж авах
10. Суралцахуйн замын зураглалд тэмдэглэл хөтлөх

Даалгавар 1 Тулгуур ойлголтуудын мөн чанар, хамаарлыг шинжлээрэй

Аль ч нийгэм өөрийн соёлтой байх бөгөөд хүн аливаа соёлын хүрээнд заавал хамрагддаг. Соёл нь хөдөлгөөнгүй зүйл биш. Тэр үүсэж хөгжиж бас доройтолд ордог. Орон зай, цаг хугацаанд соёлын өөрчлөгдөн шинэчлэгдэх талыг соёлын өөрчлөлт гэнэ. Нээлт, бүтээл, соёлын харилцан нөлөөлөл, нэвчилтын үйл явц нөлөөлнө

А. Дараахи тулгуур ойлголтуудыг тохирох тодорхойлолттой нь зөв холбож бичээрэй .

Соёлын өөрчлөлт
Соёлын хожимдол
Соёлын даяаршил

Соёлын нэвчилт
Соёлын гажилт
Соёлын дархлаа

1	Зам харилцаа, эдийн засгийн харилцаа мэдээлэл харилцааны хөгжлийн үндсэн дээр тусгаар соёлууд дэлхийн нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явц	
2	Соёл өөрийн үнэт зүйлээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлж, баталгаажуулах чадварыг хэлнэ	
3	Орон зай, цаг хугацааны хувьд соёл өөрчлөгдөн шинэчлэгдэх талыг хэлнэ	
4	Материаллаг өөрчлөлтүүд нь зан заншил, итгэл үнэмшлийн өөрчлөлтөөс түрүүлж байх	
5	Нийгэмд тогтсон хэм хэмжээ алдагдсаны улмаас соёлын нэгдэл зөрчигдөх	
6	Соёлуудын харилцан тархалт дэлгэрэх үйл явц	

Б. Дээрхи ойлголтуудын хоорондын хамаарлыг бүдүүвчээр харуулж, тайлбарлаарай


Даалгавар 2: . Дараах жишээнд хамааралтай ойлголтуудыг цэгийн оронд нөхөж бичээрэй

/Жич: сурах бичгийн 48-53 хуудсыг уншиж судлаад энэ даалгаврыг хийж гүйцэтгэнэ үү

- 1930, 1940-өөд оны үед манай улсын уламжлалт шашин, соёл, үндэсний бичиг зэргээ орхиход хүрсэн нь холбоотой
- нь эрдэм соёлын чуулган, кино наадам, урлаг спортын өдөр, үзэсгэлэн зэрэг олон хэлбэрээр илэрнэ.
- Бүх шатны сургуульд англи хэлийг зааж байна. Гадаад хэлний сургалтын төвүүд ч олширч байна. Энэ соёлын..... –ын нэг илрэл бөгөөд соёлын бүрдэл болсон -нд хэрхэн нөлөөлж байгааг харуулж байна
- Хувцасны загвар, техникийн дэвшил, шинэ барааны сурталчилгааны өөрчлөлт зэрэг олон хүчин зүйл дүр төрхийг өөрчилсөөр байна

Сонгох ойлголтууд: / Хэл, Соёлын орон зай ,Соёлын нэвчилт ,Соёлын даяаршил /

Даалгавар I - 3 Дараах бүдүүвч дэх цэгийн оронд тохирох үгийг нөхөн бичнэ үү



Даалгавар II- 4 Дараах ишлэл жишээг уншаад асуултын дагуу шинжлэн судлаарай

1. Өнөөдөр бид өндөр хөгжилтэй орнуудын хэрэглээнд байгаа бүтээгдэхүүн, үйлчилгээг өөрсдийн хэрэглээнд өндөр хурдаар нэвтрүүлж, ашиглаж байна. Гэхдээ үүнийг дагаж эдийг шүтэх хандлага, зохисгүй хэрэглээ, буруу хэвшил, зөвхөн баяжих эрмэлзлийг эрхэмлэх зэрэг гаж үзэгдлүүд илэрч байна.

2. Бид зам талбай, цэцэрлэгт хүрээлэн, гудамж, хашааны гэрэлтүүлэг гээд нүдэнд харагдахуйц олон зүйлийг бүтээж байна. Гэхдээ үүнийг зөвхөн өнгөн тал төдий юм гэж хэлж болно. Жишээ нь, наадмын үеэр бараг бүх жолооч төрийн далбаагаа машин дээрээ мандуулдаг. Харин зарим жолооч цонхоороо хог хаяад явж байхыг юу гэж үзэх вэ?

Асуулт:

1. Эдгээр жишээнд өгүүлж буй шүүмжлэлт асуудалтай чи санал нийлж байна уу ?
2. Эдгээр 2 жишээнд ямар нийтлэг асуудлыг хөндсөн байна вэ ?
3. Уг асуудлыг шийдэх хэрэгцээ шаардлага юу вэ?
4. Асуудлын шалтгаан, нөлөөлж буй хүчин зүйлийг бодит жишээгээр тайлбарлаарай?
5. Энэ асуудлыг хэрхэн шийдэх вэ? Боломжит шийдлийн хувилбар дэвшүүлээрэй

Даалгавар 5 Дараах эхүүдийг шинжлээрэй

1. Телевизийн сувгууд олон түмнийг залж, өөртөө татахын тулд тархийг нь угаан сэтгэхүйг нь дундажчилж байна. Өнөөгийн олон түмний тархи сэтгэхүй нь залхууралд орж, хов жив, сураг ажиг төдийхнөөс давахаа болилоо. Энд интернет ч зарим талаар гавшгайлан довтлогч, хөнөөн сүйтгэгч боллоо. Хэрэв хүнийг өдөр бүр телевизийн дэлгэц болон дэлхийн цахим сүлжээний шүүлтүүр муутай мэдээллээр угжаад байвал хүний, түүний эргэн тойрныхны соёлын дархлаа суларч, бүр алдагдах нь илэрхий. Телевизийн олон суваг олон нийтийн ухамсарт таалагдаж, тэднийг байлдан дагуулахын тулд америкчлал, европчлол, өрнөдийн элдэв уриа лоозон дэвшүүлэн, халамжлагч ивээгчийн дүрээр халхавчлан зүсэн зүйлээр довтолж байна.

Эх сурвалж: Ж.Отгонбаяр. Соёлын дархлаа: асуудал, шийдэл. Философи, эрх зүйн боловсрол. УБ. 2011. №11. 31 дэх тал

2. Социализмын үед монголын зан заншил, ёс суртахууны талаар хүүхдүүдэд багаас нь эхлээд зааж сургадаг байсан. Гэтэл 1990 оноос хойш эдийн засгийн анхдагч хэрэгцээний араас яваад хүнийхээ ёс суртахууныг орхигдуулсан. Өнөөгийн соёл их баруунжсан хэв маягтай болжээ. Сүүлийн үеийн залуучууд хөдөөгийн ардын амьдрал, малчны амьдралаас маш их холдож байна. Ингэснээр бид түүхээсээ ч их хол хөндий болж байна. Өөрийнөө соёлыг мэдчихээд бусдын соёлд хүндэтгэлтэй хандах ёстой юм

Эх сурвалж: Монголын нийгмийн өөрчлөлт. Улаанбаатар 2013 он

A. Асуултанд хариулаарай

1. Эхэд ямар асуудлыг хөндсөн байна вэ?
2. Соёлын дархлаа сулардагийн гол шалтгаан юу вэ?
3. Улс үндэстэн өөрийн соёлыг хадгалж үлдэхийн тулд яах ёстой вэ?

Даалгавар 6 Монгол үндэснийхээ өв соёлыг яаж хамгаалах вэ?

Өмнөх ангиудад түүх, нийгмийн ухааны хичээлээр эзэмшсэн мэдлэгтэйгээ холбон дараах хүснэгтэд цэгийн оронд гүйцээн бичээрэй

Асуулт	Хэрэгцээ шаардлага	Ач холбогдол
Монгол үндэсний өв соёлыг хэрхэн хамгаалах вэ	<ul style="list-style-type: none"> ➤ Монгол өв соёл бол Монголын <u>дархлаа</u> ➤ Хосгүй үнэт, ховор нандин, дахин давтагдашгүй шинжтэй ➤ 	<ul style="list-style-type: none"> ➤ Үндэснийхээ өв соёлыг судалж танин мэдэх ➤ Үндэсний өв соёлоо хадгалан хамгаалах, ➤

Даалгавар 7 Асуултын дагуу зөв хариултыг тохируулж ойлголтоо дахин бататгаарай


1	Улс үндэстэн бүр өөрийн соёлыг эрхэмлэдгийн үчир?	А	Соёл өөрийн үнэт зүйлсээ хамгаалж, оршин тогтнолоо бэхжүүлэн баталгаажуулах чадвар
2	Улс үндэстэн бүр өөрийн соёлыг хадгалж үлдэхийн тулд?	Б	Бусдын соёлын хуулбарлан дууриах, соёлын тулгалтанд өртөх
3	Соёлын дархлаа сулардаг гол шалтгаан?	В	Ард түмний бахархал, омогших хүч, эв нэгдлийн үндэс, тусгаар тогтнолын баталгаа учраас
4	Соёлын дархаа гэж юу вэ?	Г	Зохих хэмжээ хязгаарын дотор байх, бусад соёлоос ялгаж буй язгуур, уламжлалаа хадгалах

Даалгавар 8 Соёлын даяаршлын олон талын боломжийг харуулсан оюуны зураглал бүтээгээрэй.

Зөвлөмж: сурах бичгийн 48 талыг уншиж судлаарай

- Хамгийн чухал гэж үзсэн 6 боломжийг сонгоорой

- Яагаад чухал гэж тухайгаа тайлбарлаж бичээрэй



Тайлбар:

Даалгавар 9 Мэдээллийг уншиж, асуултын дагуу шинжлээрэй

Pepsi эсвэл **coca cola** ууж, **хотдог** идэж **windows** үйлдлийн системтэй **компьютер** дээр ажиллаж, **холливудын кино** үзэж, **англи** үгтэй дуу сонсож, **америк** маягаар хувцаслаж байгаа бол та аль хэдийн даяаршлын нөлөөнд орсон байна. Төрөлх монгол хэлээрээ зөв ярьж, алдаагүй бичиж сурахын оронд англи хэл рүү

Асуулт:

1. Бид хэр зэрэг даяаршсан вэ ?
2. Соёлын даяаршлын ямар шинж тэмдгүүд бидэнд илэрч байна вэ ?
3. Соёлын даяаршлын нөлөөнд байгаа хүн гэж хэнийг хэлэх вэ ?
4. Үндэсний соёл, соёлын даяаршил аль алийг харгалзан хөгжүүлэх бодолтой хүн олон байдаг. Чи үүнтэй санал нийлэх үү? Өөрийн санал бодлоо илэрхийлсэн эргэцүүлээ бичээрэй 80-100 үгтэй

Даалгавар 10: Дараах мэдээллийг уншаад өгөгдсөн даалгавруудыг хийнэ үү.

1990 оноос Монголд соёлын орчин үеийн ардчилсан тогтолцоо бүрдэж эхэлсэн. Ардчилсан нээлттэй нийгмийн соёл бол олон ургальч үзэл болон шүтэх бишрэх эрх чөлөөг зөвшөөрдөг нээлттэй тогтолцоо юм. Манай орны соёл энэ чиглэлээр өөрчлөгдөж, эдүгээ олон соёлын уулзвар болж байна. Нэг талаас, ардчилсан өөрчлөлтийн явцад монголчуудын үндэсний бахархал сэргэж, үндэстний соёлын өв сангаа судлах, сэргээн хэрэглэх явдал ихээхэн өргөгөжиж байна. Нөгөө талаас, бусад улс орны соёл өдөр тутмын амьдралд өргөн нэвтэрч байна. Харийн бүхнийг дээдлэхээс илүү уламжлал, ёс заншлаа хадгалах өвлүүлэх явдал бол аливаа улс үндэстний соёлын хувь чанарыг хадгалах хамгаалах гол хэрэглүүр юм. Тэдгээрт тулгуурлаж аливаа улс үндэстний гэсэн өвөрмөц соёл оршин тогтнож байдаг жамтай. Соёлын түүхчид соёл бүрт буй өвөрмөц онцлогийг илрүүлэхийг эрмэлзэхийн зэрэгцээ тэдгээрийн хоорондын залгамж холбоо, өнгөрсөн үеийн соёлын дараагийн соёлд үзүүлсэн нөлөөг судалж тодорхой болгохыг эрмэлзэж байдаг. Тухайлбал, эртний соёлын олон элемент өнөөгийн соёлд хадгалагдаж байдгийг олж тогтоожээ. Хэдийгээр соёлын үнэт зүйлс, хөшөө дурсгалыг эвдэн устгаж болох авч соёлын үнэлэмж тээгчтэйгээ хамт алга болдоггүй. Үүнийг бид ном, зохиол, дурсгалт бичиг, түүх, шашдир, ардын урлаг зэргээс бид олж харж байдаг.

Даалгавар

Хариулт

1. Мэдээлэлд соёлын ямар шинжийн тухай өгүүлж байна бэ?

2. Соёлын өөрчлөлт гэж юуг хэлэх вэ? Тодорхойлолт бичнэ үү.

3. Хэдийгээр соёлын үнэт зүйлс, хөшөө дурсгалыг эвдэн устгаж болох авч соёлын үнэлэмж тээгчтэйгээ хамт алга болдоггүй. Үүнийг жишээгээр тайлбарлан бичнэ үү.

В. Мэдээлэлд өгөгдсөн дараах дүгнэлтүүдийг ашиглан Монголын соёлын өөрчлөлтийн талаар эргэцүүлэмж бичээрэй. Үгийн тоо 250-300

Ардчилсан нээлттэй нийгмийн соёл бол олон ургальч үзэл болон шүтэх бишрэх эрх чөлөөг зөвшөөрдөг нээлттэй тогтолцоо юм.

Манай орны соёл энэ чиглэлээр өөрчлөгдөж, эдүгээ олон соёлын уулзвар болж байна.

Харийн бүхнийг дээдлэхээс илүү уламжлал, ёс заншлаа хадгалах өвлүүлэх явдал бол аливаа улс үндэстний соёлын хувь чанарыг хадгалах хамгаалах гол хэрэглүүр юм.

Бататгах сорил

Дараах нотолгоо бүрийг анхааралтай уншаад зөв, бурууг тодорхойлоорой хэрэв буруу байвал зөв болгоорой. Жич: зөв- з, буруу –б үсгээр дугаарын өмнө тэмдэглээрэй

- 1. Соёлын дархлаа хүчтэй бол соёлын адилсал алдагдана.
- 2. Аливаа соёл түүхэн үзэгдэл мөн.
- 3. Соёлын дархлаа бол өөрийн үнэт зүйлээ хамгаалах чадвар мөн.
- 4. Хүн өөр улсын соёлын тээгч байдаг.
- - 5. Соёлын орон зай нь төрсөн нутаг мөн.
- 6.Соёлын даяаршил гэдэг нь нэгдмэл соёлд нэгдэн нийлэх үйл явцыг хэлнэ.
- 7. Экосистем хүнгүйгээр оршин тогтнож чадахгүй.



ӨӨРИЙН ҮНЭЛГЭЭ

Дэд сэдэв	Дасгал даалгаврыг гүйцэтгэсэн чадвар	R	A	G	Comments
Соёлын өөрчлөлт	1.Соёлын өөрчлөлт , харилцан хамаарал, хожимдол зэрэг ойлголтуудын тодорхойлж мэдсэн	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
	2. Соёлын өөрчлөлт, харилцан хамааралд нөлөөлдөг хүчин зүйлийг жишээгээр тайлбарлаж чадна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
	3. Соёлын хожимдол, түүнээс урган гарах үр дагаврыг тодорхойлж чадна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
	4. Улс үндэстэн бүр өөрийн соёлыг эрхэмлэдгийн учир, соёлын дархлаа яагаад сулардаг болохыг мэдсэн	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
	5.Монголчуудын уламжлалт соёл, зан заншлын өвөрмөц онцлог юу вэ? Түүнийг хэрхэн хайрлан хамгаалж, авч явах вэ ? гэсэн асуултанд үндэслэлтэй хариулт өгч чадна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
	6. Соёлын даяаршил, соёлын эрх чөлөөний тухай ойлголтууд түүний үндэсний соёлд үзүүлэх нөлөөг тодорхойлж чадна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	
	7 Сэдвийн тулгуур ойлголтын хоорондын хамаарлыг харуулсан утгын зураглал зурж чадна	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	

R- Багшийн тусламж авна

A- Дахин давтаж, нэмэлт дасгал ажиллана.

G- Өөрөө сайн хийж чаддаг болсон